



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 33

Номгон

Г  
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
дэргэдэх Ахмад зөвлөхүүдийн орон тооны бус  
зөвлөлийн үйл ажиллагааны журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Ахмад зөвлөхүүдийн орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааны журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлж, үйл ажиллагаандaa чанд мөрдөж ажиллахыг Ахмад зөвлөхүүдийн орон тооны бус зөвлөлийн тэргүүн /Г.Цэрэн/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж! ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуюн/-д даалгасугай.



116017

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2017 оны 03 дугаар сарын  
18-ны өдрийн 33 дугаар тогтоолын хавсралт



БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДЭРГЭДЭХ АХМАД  
ЗӨВЛӨХҮҮДИЙН ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1. Зөвлөлийн үйл ажиллагааны зорилго нь аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн дунд болон урт хугацааны хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлоход туслах, ажил амьдралын сайн туршлагыг түгзэн дэлгэрүүлэх, шинжлэх ухаанч санал санаачилгыг дэмжсэн зөвлөмж, дүгнэлт гаргахад оршино. Үүнд:

1.1 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх, бодлогын залгамж чанарыг хангах нийгмийн сэтгэл зүй, эдийн засгийн боломж нөхцлийг сурталчлах, үр дүнд хүргэх;

1.2 Үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн хамрах хүрээг зохистой тогтоох, уялдаа холбоог сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх;

1.3 Аймгийн эдийн засгийн хөгжлийн үндсэн тулгуур болсон мал аж ахуй, газар тариалангийн талаар баримтлах бодлогын шинжлэх ухааны үндэслэлд тулгуурлан боловсруулалцаж, малчид, тариаланчдын дунд зохион байгуулах сургалт, сурталчилгаа, хэлэлцүүлэг, мэдлэгжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнд идэвхтэй оролцох, санал авах, санал зөвлөмж гаргах;


1.4 Аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх талаар тулгамдсан асуудлаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн хурал, төлөөлөгч, Засаг дарга, Засаг даргын зөвлөл, Тамгын газраас саналыг хүлээн авч, санал зөвлөмж өгөх;

1.5 Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, жил жилийн аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд санал, санаачилга гарган ажиллаж, санал зөвлөмж гаргах;

**Хоёр. Зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн**

2.1 Ахмад зөвлөхүүдийн зөвлөлийн бүрэлдэхүүнд аймгийн төр захиргаа, хууль хяналт, олон нийтийн байгууллага, боловсрол эрүүл мэнд, хөдөө аж ахуй, геологи уул уурхай, эрчим хүч, тээвэр, аж үйлдвэрийн салбарт он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, олонд танигдсан туршлагатай ахмадуудын нэрийг дэвшүүлэх, өөрсдийн хүсэлтийг хүлээн авах замаар сонгон шалгаруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж тогтоолоор батлана.

2.2 Зөвлөл нь Тэргүүлэгчид, тэднээс сонгогдсон тэргүүнтэй байна.



### **Гурав. Үйл ажиллагаа**

3.1 Зөвлөлөөс гарах албан ёсны бичиг баримт нь зөвлөмж байх бөгөөд энэ нь төр засгийн хууль тогтоомж, бодлого шийдвэрт нийцсэн байхаас гадна аль нэгэн хувь хүн, албан байгууллагын ашиг сонирхолыг илэрхийлсэн, тулган шаардсан, лоббидсон /хүчлэн ухуулсан/ өнгө аясгүй байна.

3.2 Зөвлөлийн гишүүний боловсруулсан санал санаачилга, төсөл, судалгааны материалыг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж дэмжигдвэл тооцоо судалгаа, хүрэх үр дүн, зохион байгуулах арга замыг тодорхойлсон зөвлөмжийн хамтаар аймгийн удирдлага, холбогдох байгууллагад албан ёсоор хүргүүлнэ.

3.3 Аливаа зөвлөмж гаргахдаа мэргэжлийн салбарын байгууллагын удирдах ажилтан, хамт олны зөвлөгөөнд танилцуулан зөвшөөрөгдсөн болон дэмжигдсэн байх шаардлагад нийцсэн байна.

3.4 Зөвлөлийн үйл ажиллагаа нь ахмад, эмэгтэйчүүд, залуучуудын зэрэг олон нийтийн байгууллага, улс төрийн намуудын ажилд хутгалдан орохгүй

3.5 Зөвлөлөөс гарах зөвлөмжинд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дарга, зөвлөлийн тэргүүн гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж баталгаажина.

### **Дөрөв. Төлөвлөлт**

4.1 Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь улирал тутамд 1-ээс доошгүй удаа хуралдах хуралдаан байна.

4.2 Зөвлөл нь ажлаа жил, улирлаар төлөвлөж, биелэлтийг хуралдаанаараа хэлэлцэж явц, үр дунд үнэлэлт, дүгнэлт өгнө.

4.3 Зөвлөлийн байнгын үйл ажиллагааг Зөвлөлийн тэргүүн хариуцаж ажиллана.

4.4 Зөвлөлийн ажиллах нөхцөл бололцоог иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба хангахаас нөхцөл бололцоог гадна шаардагдах зардлын асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тухай бүрд нь хэлэлцэж шийдвэрлэнэ.

### **Тав. Бусад**

5.1 Зөвлөлийн гишүүд үнэмлэхтэй байна.